



Засгийн газрын 2019 оны 204 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛЫН ОЙ, ТЭМДЭГЛЭЛТ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд зааснаас бусад түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулахад энэ журмыг мөрдөнө.
- 1.2. Монголын болон дэлхийн түүхэнд онцгой гавьяа байгуулсныг тодорхойлох шинжлэх ухааны байгууллагын бодит баримт бүхий дүгнэлтээр нотлогдсон түүхэн хүн, Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатрын мэндэлсэн болон тухайн салбар байгуулагдсан өдрөөс 100 болон түүнээс дээш 50 жилийн давтамжтай тэгш ойг тэмдэглэнэ.
- 1.3. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалтын 1.2-1.4-д заасан түүхэн үйл явдлын ойг тухайн үйл явдал болсон өдрөөс хойш 10 жилийн давтамжтай тэмдэглэнэ.
- 1.4. Байгууллагын тэгш ойг байгуулагдсан өдрөөс хойш 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн тухайн байгууллагын удирдлага холбогдох шийдвэр гаргаж тэмдэглэнэ.
- 1.5. Дараахь тохиолдолд түүхэн үйл явдал, тэмдэглэлт ойг тэмдэглэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ:
 - 1.5.1. Шинжлэх ухааны академийн дүгнэлт, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалтад ороогүй түүхэн үйл явдал, түүхэн хүний тэгш ойг;
 - 1.5.2. батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалтын 1.2-1.4-д заасан түүхэн үйл явдлын ойг;
 - 1.5.3. гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн олон улсын хэмжээний түүхэн үйл явдлын тэгш ойг.
- 1.6. Салбарын тэгш ойг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон нутгийн байгууллагын тэгш ойг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тэмдэглэнэ.
- 1.7. Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатрыг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх зорилгоор түүний тэгш ойг тэмдэглэх асуудлыг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

1.8. Нэгдсэн Үндэстний байгууллага, түүний төрөлжсөн болон олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр шийдвэрлэсэн, зөвлөмж болгосон тэмдэглэлт өдрийг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

Хоёр. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх

2.1. Түүхэн үйл явдал, түүхэн хүн, энэ журмын 1.7-д заасан ойг тэмдэглэх ажлын хүрээнд дараахь арга хэмжээг зохион байгуулж болно:

2.1.1. түүхэн үйл явдлын болон түүхэн хүний гавьяа, гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдол, сургамжийг хүүхэд, залууст танин мэдүүлж, сурталчлах;

2.1.2. шинжлэх ухааны тодорхой салбар, чиглэлээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;

2.1.3 урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах;

2.1.4. ном, кино бүтээх;

2.1.5. хөшөө, дурсгалын самбар, багана босгох;

2.1.6. бусад.

2.2. Салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тэмдэглэх өдрийн хүрээнд тухайн жилд тодорхой сэдэв, уриан дор дараахь арга хэмжээг зохион байгуулж болно:

2.2.1. тухайн салбарын ололт амжилтыг олон нийтэд мэдээлж сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох;

2.2.2. иргэдэд үйлчилгээ үзүүлэх, тэдний санал, хүсэлтийг сонсох, бүтээлч ажил, үйл ажиллагаанд оролцуулах;

2.2.3. ажилтан ажилчдын хөдөлмөр, бүтээлийг тодруулан алдаршуулах, хөдөлмөрийн алдар тэмдэглэх, шагнаж урамшуулах;

2.2.4. үдэшлэг, өдөрлөг, оюун ухаан сорих болон биеийн тамирын тэмцээн, ажил, мэргэжлийн уралдаан зохиох.

2.3. Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх асуудлыг тухайн байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтөө тусган батлуулж, зардлын гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана.

2.4. Аймаг, нийслэлд хөшөө, дурсгалын самбар, багана босгох тохиолдолд түүний загвар, тодорхойлолтыг орчны архитектур төлөвлөлттэй уялдуулан аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагын гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар батална.

2.5. Түүхэн үйл явдал, ойг тэмдэглэхэд шаардагдах зардлыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, төрийн бус байгууллагын хандив, ивээн тэтгэгчдийн хөрөнгөөр санхүүжүүлж болно.

-----o0o-----